



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/381


Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журам", Музейн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, Соёлын сайдын 2023 оны А/380 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.2 дахь хэсэг, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 38 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийг судлах музейн сан хөмрөгийг музейн шинэ барилгад нүүлгэн шилжүүлэх ажлын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дэмжлэгт шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э. Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР